

**Улаанбаатар Цэвэр Агаар
Санаачлага II үе**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
“Ногоон Хөгжлийн Хөтөч” ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК-тай хамтран боловсруулав.**

*Цэвэр агаар сан (ЦАС)-гийн бүтэц зохион байгуулалт
ба ажлын даалгавар
Бүтээгдэхүүн 3.4.3*

2012 оны 6-р сарын 11



Улаанбаатар Цэвэр Агаар сан – II үе

Гэрээний дугаар: 22384/EBSF2009-09-
117/01

Цэвэр агаар сан(ЦАС) -гийн бүтэц зохион
байгуулалт (3.4.3)

2012 оны 6-р сар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Европын сэргээн босголт, хөгжлийн банк

БОАЖЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Мотт Макдоналдс Амстердамсеевг 15, 6814 CM Арнхем, Шуудангийн хайрцаг 441, 6800
АК Арнхем Нидерланд улс **Утас:**+31 (0) 26 357 7111, **Факс:** +31 (0) 26 357 7577
И-мэйл: euroconsult@mottmac.nl, **вeб хуудас:** www.euroconsult.nl

Цэвэр агаар сангийн (ЦАС) байгууллагын бүтэц зохион байгуулалт ба ажлын даалгавар

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
1	2012-6-11	Онно ван ден Хеувел Д.Эрдэнэ	Пиет де Вилдт		

Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага 2 үе

Улаанбаатар хотын гэр хороололд уламжлалт зууханд чанар муутай нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад тус хотод бий болдог агаарын бохирдлын томоохон шалтгаан болдог. Улаанбаатар хотын агаарын чанарын доройтол нь хотын оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, илүү хэмнэлттэй түлшээр солих нь тус Улаанбаатар хотод тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай хангалт, чанар тэдгээрийг дэмжсэн хууль эрхзүйн орчин, стандартуудыг гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн Газар орлуулах түлшний үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-наас хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн Газартай 2008 оны 9-р сараас түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр орлуулах төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний гол хэсгүүдийг 2009 оны 6-р сард Засгийн Газраар батлуулахаар өргөн барьсан Түлш орлуулах үйл ажиллагааны ерөнхий хүрээнд тусгасан. Засгийн газар Үйл ажиллагааны хүрээ гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын Их хурал Агаарын багц хуулиудыг батласаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болж Үйл ажиллагааны үйл ажиллагааны ерөнхий хүрээ гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь Үйл ажиллагааны ерөнхий хүрээ холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэх шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгоор, зөвхөн ашиглах эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Энэхүү баримт бичгийг өөр бусад талууд өөр зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад үзүүлэхийг хориглоно.

Агуулга

	Хуудас
Товчилсон үгийн жагсаалт	ii
Оршил	iii
1 Удиртгал	1
2 ЦАС-гийн албан ёсны эрх үүрэг, бүтэц зохион байгуулалт	2
2.3 Бүтэц зохион байгуулалтын нарийвчилсан бүдүүвч _____	3
Хавсралтууд	
Хавсралт 1: ЦАС-гийн бүтэц зохион байгуулалтын бүдүүвч- хувилбарууд.....	6
Хавсралт 2: ЦАС-гийн боловсон хүчин: ажилтан бүрийн ажлын даалгавар.....	10
Хавсралт 3: 5 Нэмэлт боловсон хүчний ажлын даалгавар.....	24
Хүснэгтүүд	
Хүснэгт 1: Бүтээгдэхүүний хүснэгт	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

ЦАС
ЕСБХБ
БОАЖЯ
УБЦАС

Цэвэр агаар сан
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага

Оршил

Цэвэр агаар сан (ЦАС) нь эхний ажилтнуудаа сонгон 2011 оны эхний хагаст үйл ажиллагаагаа эхлүүлсэн. “Улаанбаатар цэвэр агаар II” төслөөс бүтэц зохион байгуулалтын тогтолцоог хянан үзэж, Сангийн хүний нөөцийн өнөөгийн ба цаашдын бүтэц бүрэлдэхүүн, ажилтнуудын албан даалгаваруудыг боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Одоогоор төлөвлөж буй ихэнхи ажлын байруудад ажилтнуудыг бүрэн бүрэлдэхүүнээр авч ажиллуулаагүй байгаа болохоор Сангийн цаашдын бүтцийг үндсэн 3 бүдүүвч зургаар авч үзлээ. Эдгээр зургуудад Санд авч ажиллуулах ажилтнуудыг тодорхойлж, тэдгээрийг авч ажиллуулснаар нэгдсэн арга барил бүхий “тэнцвэртэй” баг бүрдэх нэлээд “тохиромжтой” бүтэц юм. Сангийн ажилтнуудын нарийвчилсан албан даалгавруудыг урьдчилсан байдлаар гаргасан бөгөөд цаашид ажилтнуудыг албан ёсоор авч ажиллуулах явцад шинэчлэн боловсронгуй болгох боломжтой.

1 Удиртгал

“Улаанбаатар цэвэр агаарын санаачлалага II” төсөл Албан даалгаврын 3.4.3-т заасны дагуу Цэвэр агаар сан (ЦАС)-гийн бүтэц зохион байгуулалтыг хянаж үзээд Сангийн бүтэц зохион байгуулалт болон ажилтнуудын албан даалгавруудыг илүү нарийвчлан гаргалаа. Түүнчлэн төслийн баг холбогдох гол хууль, бодлогын баримт бичгүүдийг судалж, ЦАС-гийн болон бусад харилцагч талуудтай уулзаж ярилцлаа. ЦАС нь Төрийн тусгай бусад 28 сангийн нэг адил Төрийн тусгай сангийн тухай хууль болон Агаарын тухай болон Агаарын төлбөрийн тухай хуулиудыг мөрдлөг болгодог. Тус Сан нь Монгол Улсын хууль тогтоомжуудыг бүрэн дагаж ажиллах хэдий ч зарим тодорхой асуудлаар тусгайлан өөрийн журам гарган ажиллаж болно. Энэхүү баримт бичгийг боловсруулж гаргах үед Засгийн газраас ЦАС-нд нэмж ажилтан авах талаар тодорхой шийдвэр гаргаагүй байсан. Гэхдээ цаашид ЦАС-г өргөжүүлэх хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд хэрхэн өргөжүүлэх талаар тодорхой чиглэл, ажил үүргийн нарийвчилсан хуваарийг энэхүү баримт бичгээс харж болно. Улаанбаатар цэвэр агаарын санаачлага 2 төсөл ЦАС-гийн ажлын байрнуудыг түүний бүтэц зохион байгуулалтын ерөнхий бүдүүвчид харуулсны зэрэгцээ нэг жилийн хугацаанд Үндэсний хороо болон ЦАС-д нэмэлт ажилтныг оролцуулан шууд дэмжлэг үзүүлж ирсэн ба ажилтны Ажил үүргийн хуваарийг тайланд мөн оруулсан.

2 ЦАС-гийн албан ёсны эрх үүрэг, бүтэц зохион байгуулалт

2.1 Цэвэр агаарын сангийн үүрэг, зорилго

Цэвэр агаарын сан, түүний бүтэц зохион байгуулалтыг 2010-2011 онд боловсруулж бий болгосон. Сангийн хууль эрх зүйн үндсийг тодорхойлсон хуулиуд батлагдсны дараа уг Санг Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны дэргэд байгуулахаар болсон. Санг ажиллуулж эхлэхээр түүний Удирдах зөвлөлийн дүрмийг шаардлагатай санхүүжилтийн хамт 2010-10 сард 273 тоот тогтоолоор батласан. Уг шийдвэрийн дараа Удирдах зөвлөлийн анхны уулзалтаар Сангийн Гүйцэтгэх захирлыг томилосон. ЦАС-гийн Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн БОАЖЯ 2011 онд ЦАС-гийн дүрэм, ЦАС-гийн бүтэц зохион байгуулалт, стратегийг хавсралтаар баталсан. 2011-5 сард Сан эхний ажилтнуудаа авч ажиллуулан үйл ажиллагаагаа албан ёсоор эхэлсэн.

ЦАС-гийн стратегид дараахи зорилго зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

Зорилго: *“Тусгай сангийн тухай хуулийн 5.1-д заасанчлан агаарыг хамгаалах, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулагч бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбоотой Сангийн үйл ажиллагааг хөгжүүлэх, санхүүжилтийг эдгээр үйл ажиллагаанд зориулсан улсын нэгдсэн төсөв, хандив, тусоамжаас бүрдүүлэх”;*

Зорилт: *“агаарыг хамгаалах, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулагч бодисын хаягдлыг бууруулах зэрэг үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх; эдгээр үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бий болгох, Сангийн дэмжлэг, санхүүжилтийг үндэслэлтэй, үр дүнтэй зарцуулах”.*

Энэ үүрэгт нэн тэргүүнд авч үзэх асуудлуудыг тодорхойлж, ЦАС-г агаарын бохирдлын ямар элементүүдэд чиглэхийг тодорхой заагаагүй нэлээд өргөн хүрээгээр авч үзсэн байна. Тийм болохоор агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой төрөл бүрийн асуудлыг өргөн хүрээгээр авч үзсэн байна. ЦАС-гийн зорилго, зорилтыг тогтоосон ч түүний эрхэм зорилго, хүрэх үр дүнг тогтоож өгөөгүй мэт харагдаж байна.

Хугацаа: ЦАС-гийн үйл ажиллагааны хугацааг тодорхой тавиагүй байна.


Газар зүйн хамрах хүрээ: Сан нь эхний ээлжинд Улаанбаатар хотод чиглэх бөгөөд 2012 оноос Эрдэнэт, Дархан, Сайншанд зэрэг хоёрдогч хотуудад үйл ажиллагаагаа өргөжүүлж болно. 2013 оноос үндэсний хэмжээнд ажиллах болно.

Зөвлөмж:

ЦАС-гийн үүргийг тухайлбал: нүүрстөрөгчийн давхар исэл / CO₂/, азотын давхар исэл / NO_x/, хүхэрлэг хий /SO_x/ зэрэг агаар бохирдуулагч тодорхой бодисуудыг бууруулахад чиглэсэн зорилтуудад чиглүүлэх хэрэгтэй. Энд тодорхой зорилтуудыг тавьж тэдгээрийг Үндэсний хөгжлийн стратеги болон ЦАС-гийн стратеги зэрэг бодлогын баримт бичгүүдэд нэмж тусгаж өгөх хэрэгтэй. Энэ нь ЦАС-г үр дүнд чиглэсэн үйл ажиллагаатай болгоход туслах болно.

2.2. ЦАС-гийн өнөөгийн бүтэц зохион байгуулалт

ЦАС нь одоогийн ажиллаж байгаа ажилтан/хүний нөөцдөө тулгуурлан түр хугацааны бүтэц зохион байгуулалтын бүтцээр ажиллаж байна. Бүдүүвчийг Зураг 1-д үзүүлэв. Сангийн үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд уг энгийн бүтцийг гаргасан. Улаанбаатар цэвэр агаарын санаачлага 2 төсөл Сангийн бүтэц зохион байгуулалтыг нарийвчлан гаргах, цаашид авч ажиллуулах ажилтнуудын Ажил үүргийн хуваарийг боловсруулахад туслан ажиллалаа.




Зураг 1: Өнөөгийн бүтэц зохион байгуулалтын бүдүүвч

2.3 Бүтэц зохион байгуулалтын нарийвчилсан бүдүүвч

Сангийн бүтэц зохион байгуулалтын нарийвчилсан бүдүүвчийг гарган ЦАС-гийн удирдлагатай хэлэлцсэн. Уг бүдүүвчийг ЦАС-гийн зүгээс төлөвлөж байгаа 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах үйл ажиллагааны ерөнхий бүтцэд тулгуурлан гаргалаа. Энэхүү шинэчлэгдсэн бүтцээр ЦАС-гийн ажилтан боловсон хүчнийг ажил үүргийн хувьд дараахи 3 нэгжид хуваасан. Үүнд:

1. Төслийн үндэсний хяналтын нэгж нь Монгол улсын Засгийн газрын зүгээс үндэсний хэмжээнд нэн тэргүүнд авч үзсэн асуудлуудад чиглэсэн үйл ажиллагаа/төслийг боловсруулж, өөрийн орлогоор санхүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй ажиллана.
2. Донор төслүүдийн нэгж нь донор байгууллагуудын санхүүжүүлдэг төслүүдтэй адил үйл ажиллагаа явуулах ба мэдээлэл/сурталчилгааны асуудлыг хариуцан ажиллана.
3. Үйл ажиллагааны нэгж нь байгууллага нь төр засгийн байгууллагуудад тавигддаг шаардлагуудад нийцүүлэн явуулж үүрэгтэй бөгөөд сангийн ажилтан, боловсон хүчнийг удирдан зохион байгуулах үүргийг Гүйцэтгэх захиралд төвлөрүүлнэ.

Доор бүтэц зохион байгуулалтын бүдүүвчийг хэсэг, нэгж бүрийн үндсэн чиг үүргийн хамт дэлгэрэнгүйгээр өгсөн ба өөр хувилбарыг Хавсралт I-д үзүүлэв.



1. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Хуулиар Сайд санг албан ёсоор хариуцан ажиллана. Иймээс ЦАС нь Сайдад шууд ажлаа тайлагнана. Сайд Удирдах зөвлөлийг удирдах ба ЦАС –гийн Гүйцэтгэх захирлыг томилно. Энэ нь түүнд агаарын бохирдлын бодлого, санхүүжилтийн асуудлаар үр дүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах боломж олгож байгаа юм.

2. УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Удирдах зөвлөл нь дараахи бүтэцтэйгээр байгуулагдсан. Үүнд:

Дарга
Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд

Орлогч дарга
Сангийн сайд



Гишүүд

1. Эрүүл мэндийн сайд
2. Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын дарга (Зам тээвэр, барилга, хот байгууллагын яам)
3. Түлшний бодлогын газрын дарга (Эрдэс баялаг, эрчим хүчний яам)
4. УБ хотын Орлогч дарга (үйлдвэр, экологийн асуудал хариуцсан орлогч)
5. Агаарын чанарын мэргэжлийн улсын албаны дарга
6. Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч
7. Байгаль орчин иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн



Нарийн бичгийн дарга нарын газар
Байгалийн нөөцийн газрын
дарга (БОАЖЯ)

Удирдах зөвлөлийн чиг үүргийг түүний дүрэмд дараахи байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, олон талуудын оролцоог хангах
- Ерөнхий сайд удирдах зөвлөлийн гишүүдийг томилно
- Гишүүдийн 50% ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болно
- Шийдвэр нь олонхийн саналд тулгуурлана

- Хурал 6 сард нэг удаа хуралдана. Гэхдээ наад зах нь 3 сард нэг удаа хуралддаг байна.
- Хурлын тэмдэглэлд дарга ба нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- Удирдах зөвлөлийн шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.
- Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа:
 1. Үйл ажиллагааны төлөвлөгөө, зарцуулалтын тайланг хэлэлцэж, батлах
 2. Сангийн дүрэмд өөрчлөлт оруулж, батлах
 3. Гүйцэтгэх удирдлагын ажилтнуудыг томилж, чөлөөлөх
 4. ЦАС-гийн төсөл хөтөлбөрийн төсвийг батлах
 5. Үйл ажиллагаа ба зарцуулалтанд хяналт тавих
 6. ЦАС-гийн гүйцэтгэх удирдлагын ажилтнуудыг үйл ажиллагааг тогтмол хянах
 7. Үйл ажиллагааны төсөв, зарцуулалтын тайланг засгийн газрын холбогдох гишүүд, бусад холбогдон албаны хүмүүст хүргүүлэх
 8. ЦАС-г холбогдох тоо баримт/мэдээллэр хангах

Энэхүү баримт бичгийг боловсруулж гаргах үеийн байдлаар Удирдах зөвлөл 3 удаа хуралдаад байна. Анхны хурлаар ЦАС-гийн захирлыг томилсон.

Зөвлөмж: Хоёр байгууллагын хоорондын ажлын уялдааг хангах үүднээс Агаарын бохирдлыг багасгах Үндэсний хорооны нэг төлөөллийг Зөвлөлд оруулах хэрэгтэй.

3. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөл томилно. Гүйцэтгэх захирлын үүрэг, хариуцлагыг ЦАС-гийн дүрэмд дэлгэрэнгүй тусгаж өгсөн байх бөгөөд дараахи үүргүүд багтсан байна. Үүнд:

- Төсвийн зарцуулалттай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах
- Үйл ажиллагааг зохион байгуулах,
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавих,
- Удирдах зөвлөлд жил тутмын үйл ажиллагааг танилцуулах, санхүүгийн тайлан, балансыг бэлтгэх, аудит хийлгэх,
- Удирдах зөвлөлийг шаардлагатай мэдээллээр хангах,
- Сангийн удирдлагыг бий болгох, зохион байгуулах, удирдах
- Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллуудад хандах

Гүйцэтгэх захирал нь мөн бусад үүргийг гүйцэтгэдэг (ЦАС-гийн стратегид тусгагдаагүй):

- Тэргүүн шадар сайдын зөвлөх
- Агаарын бохирдолтой тэмцэх үндэсний хорооны гишүүн
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны гишүүн

Түүнчлэн Гүйцэтгэх захирал дараахи үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд.

- Үндэсний хэмжээний төслүүдийг санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

4. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТӨСЛҮҮД

- Төслийн үндэсний ажилтан
- Байгаль орчны аюулгүй байдлыг хариуцсан ажилтан
- Дэд бүтэц, боловсруулсан түлш хариуцсан ажилтан
- Халаалтын систем хариуцсан ажилтан
- Сургалт, судалгаа, олон нийтийн мэдээллийн ажилтан
- Хот байгуулалтын ажилтан

Энэ нэгж нь Засгийн газраас санхүүжиж буй төслүүдийг боловсруулах, үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй ажиллана. Төслүүд нь улсын хэмжээнд нэн тэргүүний асуудлуудад чиглэсэн байхаас гадна бохирдуулагч бодис, тэдгээрийн ялгаруулалтыг бууруулах ажлыг зардал хэмнэлттэй явуулж байгаа эсэхт анхаарлаа хандуулна. Тус нэгж нь үйл ажиллагааны мониторинг, хэрэгжилтийн асуудлаар төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах үүрэгтэй. Тус нэгж нь ЦАС-гийн эн тэргүүний асуудлаар урт хугацааны стратеги, жилийн ажлын төлөвлөгөөгөө гарган ажиллана.

Одоогийн байдлаар Сангийн бүх ажилтныг Гүйцэтгэх захирал удирдан ажиллана.

Одоогийн төлөвлөж байгаа бүтцийг Ажлын даалгавар/ажил үүргийн дэлгэрэнгүй хуваарийг Хавсралт 2-т үзүүлэв..

5. ДОНОР ТӨСЛҮҮД

- Олон нийтийн сурталчилгаа, Харилцаа холбооны ажилтан
- Олон улсын төслүүд хариуцсан ажилтан

Энэ нэгж нь гадаад харилцаатай холбоотой асуудлыг хариуцан ажиллана. Энэ нь ЦАС-гаас санхүүжилт нь шууд хийгддэггүй ч агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн донор байгууллагуудын хэрэгжүүлж буй төслүүд, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана. Түүнчлэн тус нэгж нь ЦАС-гийн вэб хуудас болон Үндэсний төслийн багтай хамтран олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажлууд, кампанит ажлуудыг зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцаж ажиллана. Энэ зорилгоор тус нэгж нь харилцаа, холбооны стратегийг боловсруулах үүрэгтэй ажиллана. Түүнчлэн нөөц бүрдүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллах ба түүний хэрэгжилтийг жил тутам үнэлдэг байна. Хэвлэлийн мэдэгдэл гаргах, мэдээллээ вэб хуудаснаа байрлуулах нь ЦАС-гийн үйл ажиллагаа ба үр дүнг олон нийт, харилцагч байгууллагуудад хүргэхэд туслана.

Одоогийн байдлаар Сангийн бүх ажилтныг Гүйцэтгэх захирал удирдан ажиллана.

Одоогийн төлөвлөж байгаа бүтцийг Ажлын даалгавар/ажил үүргийн дэлгэрэнгүй хуваарийг Хавсралт 2-т үзүүлэв.

6. ҮЙЛ АЖИЛЛАГАА


- Ахлах нягтлан бодогч
- Нярав
- МТ-ийн вэб мастер
- Хуулийн ажилтан
- Нарийн бичиг
- Жолооч нар

Үйл ажиллагааны нэгжийн үндсэн үүрэг нь ЦАС-г үйл ажиллагаагаа явуулахад хүний, санхүүгийн, бусад шаардлагатай нөөц хангалттай байгаа эсэхт хяналт тавьж ажиллахад чиглэнэ. Түүнчлэн ЦАС-гийн санхүүжилтийг Монгол улсын Засгийн газрын дүрэм журмын хүрээнд болон бусад донор байгууллагуудын тавьдаг шаардлагын хүрээнд зарцуулж байгаа эсэхт хяналт тавина. Тус нэгж нь байгууллагын үйл ажиллагааны бүх баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх бөгөөд тэдгээр нь Монгол улсын хууль тогтоомжтой нийцэж байгаад эсэхийг баталгаажуулж ажиллана. Тус нэгж нь шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал ба төслийн нэгжүүдэд хууль эрхзүй ба удирдлагын асуудлаар зөвлөх үүрэгтэй ажиллана. Түүнчлэн ЦАС-гийн өдөр тутмын үйл ажиллагааг хангах тухайлбал ажилтнуудад шаардлагатай ажлын байрны талбай, тоног төхөөрөмж, унаа тээврийн хэрэгсэл зэргийг зохицуулах үүрэг хүлээнэ.

Одоогийн байдлаар Сангийн бүх ажилтныг Гүйцэтгэх захирал удирдан ажиллана.

Одоогийн төлөвлөж байгаа бүтцийг Ажлын даалгавар/ажил үүргийн дэлгэрэнгүй хуваарийг Хавсралт 2-т үзүүлэв.

Хавсралтууд




Хавсралт 1: ЦАС-гийн бүтэц зохион байгуулалтын схем-хувилбарууд

1. ТЭНЦВЭРТЭЙ БҮТЭЦ

- Аажимдаа өргөжүүлэх

Энэхүү тэнцвэртэй баг бүрдүүлж ЦАС –гаар санхүүжүүлж хэрэгжүүлэр үйл ажиллагааны олон талт асуудлыг зөв оновчтой боловсруулж, хяналт тавих боломж олгоно. Энэ нь ЦАС-г гадны мэргэжилтнүүдтэй ажиллах хэрэгцээг бууруулж, байгаль орчин, нийгмийн зэрэг асуудлуудыг орхигдуулахгүй байх, зарим үйл ажиллагаатай холбоотой гарч болох эрсдлийг бууруулахад чиглэнэ. Энэ бүтцэд ажлын уялдаа холбоотой ажиллах 3 нэгжийг бий болгон, өөр нэмэлт удирдлага бий болгохгүйгээр ЦАС-гийн Гүйцэтгэх захирал шууд удирдан ажиллахаар төлөвлөж оруулав.



2. ОНОВЧТОЙ БҮТЭЦ

Үйл ажиллагаа нэлээд өргөжих үед бий болгох бүтэц

Энэ хувилбарыг хэдэн жилийн дараа үйл ажиллагаа нэлээд өргөжин бүс, орон нутагт чиглэх тохиолдолд ашиглаж болно. Энэ бүтэц нь Дархан, Эрдэнэт зэрэг хотууд бусад бүсэд агаарын бохирдол гол асуудлын нэг болсон газруудад ЦАС-гийн үйл ажиллагаа өргөжих тохиолдолд ашиглах боломжтой. Орон нутгийн салбар, тэдгээрийн хэмжээ, бүтэц ямар байх нь тэдгээрийн хэрэгцээ шаардлагад үндэслэнэ.



3. ҮНДСЭН СУУРЬ БҮТЭЦ Бага зэрэг өргөжих үед байгуулах бүтэц

Энэ хувилбарыг Сангийн үйл ажиллагааны одоогийн түвшинг бага зэрэг өргөжүүлэх ба үндсэндээ одоогийн бүтцээр ажиллах үед ашиглах боломжтой. Ажилтнууд тус бүр өөр өөрийн үйл ажиллагааны чиглэлээр ажиллан тэдгээрт шууд хяналт тавих зарчмаар ажиллана.

Хавсралт 2 ЦАС-гийн хүний нөөц: ажилтан бүрийн ажлын даалгавар

ЦЭВЭР АГААР САНГИЙН (ЦАС) АЖЛЫН ДААЛГАВАР

Албан тушаал: Үндэсний төслүүд хариуцсан ажилтан

Хугацаа: Байнгын ба үндсэн ажилтан

Ажиллах байршил: ЦАС-гийн байр, Улаанбаатар хот

Цалин хөлс: Цалин хөлсийн хэмжээг Төрийн албан хаагчийн тухай хууль ба Тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн, тухайн ажилтны боловсролын байдал, ажлын туршлагад тулгуурлан тогтооно.

Үндэслэл: Сүүлийн 10 жилд агаарын бохирдол нь хот суурин газар оршин суудаг Монголчуудын хувьд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудлуудын нэг болсон юм. SO₂ ба NO₂-ын хэмжээ маш ихээр нэмэгдсэн ба ялангуяа нарийн ширхэгт тоосонцрын хэмжээ нь олон улсын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан байгаа нь сэтгэл түгшээх хэмжээнд хүрээд байна. Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах тал дээр хэд хэдэн ажиллагаа хийгдсэн болно. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоог бүрдүүлсэн агаарын тухай 3 хууль батлагдсан. Үр дүнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ба Цэвэр агаар сан (ЦАС) зэрэг хоёр чухал ач холбогдолтой төрийн байгууллага байгуулагдсан юм. 2011 онд байгуулагдсан ЦАС нь Монгол улсад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлэх гол механизм юм.

Үндсэн үүрэг даалгавар

ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын удирдлаган дор Үндэсний төсөл, хөтөлбөр хариуцсан ажилтан нь дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ:

- ЦАС-гийн зүгээс санхүүждэг бүх төсөл хөтөлбөрийн ерөнхий хяналт зохицуулалтыг гүйцэтгэх үүрэгтэй. Гүйцэтгэх захирал ба ЦАС-гийн Удирдах зөвлөлөөр дүгнэлт хийлгэх, батлуулах зорилгоор шинэ төслүүдийн концепцийн баримт боловсруулах. Энэ салбарын төслүүдийг мониторинг хийж ЦАС-гийн Гүйцэтгэх захиралд буцаан тайлагнах. ЦАС-гийн санхүүжүүлдэг үйл ажиллагаануудын талаар санал сэтгэгдэл авах зорилгоор дэд гэрээлэгч ба төслийн үр ашгийг хүртэгч талуудтай уулзах.
- ЦАС-гийн төслүүд нь нарийн ширхэгт тоосонцор, SO₂, NO₂, озон ба CO₂ зэрэг гол бохирдуулагчийн ялгарлыг бодитоор бууруулах тал дээр уялдаа холбоотой хандлага, чиглэлтэй байх мөн төрийн эн тэргүүний асуудлуудтай нэг чиглэлд байх
- Үндэсний хороо, УБ хотын захиргаа, бусад яамд, хувийн хэвшил, ТББ, төслийн үр ашгийг хүртэгч нар зэрэг холбогдох оролцогч талуудтай сүлжээ бий болгон ажиллах. Агаарын бохирдлын талаар мэдлэг, мэдээллийг сайжруулахад хувь нэмэр оруулах ба ЦАС-гийн үйл ажиллагааг олонд таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцан уялдаатай ажиллах.
- ЦАС-гийн төслүүдэд зориулан Мониторинг, үнэлгэний төлөвлөгөө боловсруулах мөн үр нөлөө ба үр дүнг хэмжих үзүүлэлтийг боловсруулах.

- Тендэрийн материал боловсруулахад хувь нэмэр оруулах, тендэрийг дүгнэх багт оролцох.
- ЦАС-гийн тайлагнах ажилд хувь нэмэр оруулах. ЦАС ба түүний төслүүдийн хэвийн ажиллагааг хангахад шаардагдах бусад үүргүүд

Тавигдах шаардлага

○ Төрийн удирдлага болон бусад холбогдох чиглэлээр мастерийн зэрэгтэй
○ Холбогдох чиглэлээр хамгийн багадаа 3 жилийн ажлын туршлагатай
○ Монгол улсын агаарын бохирдлын бодлогын талаар өргөн мэдлэгтэй
○ Компьютерийн өргөн хэрэглээний програмууд дээр ажилладаг
○ Монгол хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай ба Англи болон бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
○ Харилцаа, холбооны өндөр ур чадвартай

ЦЭВЭР АГААР САНГИЙН (ЦАС) АЖЛЫН ДААЛГАВАР

Албан тушаал: Орчны эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн

Хугацаа: Байнгын ба үндсэн ажилтан

Ажиллах байршил: ЦАС-гийн байр, Улаанбаатар хот

Цалин хөлс: Цалин хөлсийн хэмжээг Төрийн албан хаагчийн тухай хууль ба Тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн, тухайн ажилтны боловсролын байдал, ажлын туршлагад тулгуурлан тогтооно.

Үндэслэл: Сүүлийн 10 жилд агаарын бохирдол нь хот суурин газар оршин суудаг Монголчуудын хувьд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудлуудын нэг болсон юм. SO₂ ба NO₂-ын хэмжээ маш ихээр нэмэгдсэн ба ялангуяа нарийн ширхэглэг тоосонцрын хэмжээ нь олон улсын стандарт хэмжээг сэтгэл түгшээх хэмжээнд хэтэрсэн болно. Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах тал дээр хэд хэдэн ажиллагаа хийгдсэн болно. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоог бүрдүүлсэн агаарын тухай 3 хууль батлагдсан. Үр дүнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ба Цэвэр агаар сан (ЦАС) зэрэг хоёр чухал ач холбогдолтой төрийн байгууллага байгуулагдсан юм. 2011 онд байгуулагдсан ЦАС нь Монгол улсад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлэх гол механизм юм.

Гол үүрэг даалгавар

ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын удирдлаган дор Орчны эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн нь дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ:

- ЦАС-гийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах мөн байгаль орчны мониторингийн төлөвлөгөө боловсруулах. Нарийн ширхэгт тоосонцор, PM, NO_x, SO_x, CO₂ зэрэг гол бохирдуулагчийн ялгарлыг буурсан байдлыг хэмжихэд тодорхой шалгуур үзүүлэлт шаардлагатай юм.
- ЦАС-гийн зүгээс санхүүжиж буй үйл ажиллагаануудад байгаль орчны мониторинг тогтмол хийх.
- ЦАС-гийн үйл ажиллагаа нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор байгаль орчны бодлого, стандартуудыг судлах, шинэ, шинэчлэгдсэн бодлого, стандартуудыг боловсруулах процесст дэмжлэг үзүүлэх.
- ЦАС-гийн зүгээс санхүүжиж буй үйл ажиллагаа тус бүрийн байгаль орчны болзошгүй мөн бодит нөлөөллийг судлах, сөрөг нөлөөллийг бууруулах, хохирлыг барагдуулах зорилгоор засвар, шинэчлэл санал болгох
- Байгаль орчны журам боловсруулах, ЦАС-ны байгаль орчны асуудлаар холбогдох дүрэм журам/зохицуулалтын орчин, баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулахад хувь нэмэр оруулах,
- Эрчим хүчний хэмнэлт мөн байгаль орчны бусад асуудлуудын талаар ЦАС ба бусад байгууллагуудад таниулах үйл ажиллагаа зохион байгуулах, ЦАС-гийн үйл ажиллагаанд зориулан ногоон байгууламжийн бодлого боловсруулах.
- ЦАС-гийн үйл ажиллагаанд шаардлагатай бусад бүх үүрэг

Тавигдах шаардлага

○ Байгаль орчны менежмент болон бусад холбогдох чиглэлээр мастерийн зэрэгтэй
○ Холбогдох чиглэлээр хамгийн багадаа 3 жилийн ажлын туршлагатай
○ Монгол улсын агаарын бохирдлын бодлогын талаар өргөн мэдлэгтэй
○ Компьютерийн өргөн хэрэглээний програмууд дээр ажилладаг
○ Монгол хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай ба Англи болон бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
○ Харилцаа, холбооны өндөр ур чадвартай

ЦЭВЭР АГААР САНГИЙН (ЦАС) АЖЛЫН ДААЛГАВАР

Албан тушаал: Хот төлөвлөлт, дэд бүтэц хариуцсан ажилтан

Хугацаа: Байнгын ба үндсэн ажилтан

Ажиллах байршил: ЦАС-гийн байр, Улаанбаатар хот

Цалин хөлс: Цалин хөлсийн хэмжээг Төрийн албан хаагчийн тухай хууль ба Тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн, тухайн ажилтны боловсролын байдал, ажлын туршлагад тулгуурлан тогтооно.

Үндэслэл: Сүүлийн 10 жилд агаарын бохирдол нь хот суурин газар оршин суудаг Монголчуудын хувьд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудлуудын нэг болсон юм. SO₂ ба NO₂-ын хэмжээ маш ихээр нэмэгдсэн ба ялангуяа нарийн ширхэглэг тоосонцрын хэмжээ нь олон улсын стандарт хэмжээг сэтгэл түгшээх хэмжээнд хэтэрсэн болно. Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах тал дээр хэд хэдэн ажиллагаа хийгдсэн болно. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоог бүрдүүлсэн агаарын тухай 3 хууль батлагдсан. Үр дүнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ба Цэвэр агаар сан (ЦАС) зэрэг хоёр чухал ач холбогдолтой төрийн байгууллага байгуулагдсан юм. 2011 онд байгуулагдсан ЦАС нь Монгол улсад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлэх гол механизм юм.

Гол үүрэг даалгавар

ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын удирдлаган дор Хот төлөвлөлт, дэд бүтэц хариуцсан ажилтан нь дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ:

- ЦАС-гийн зүгээс санхүүждэг хот байгуулалт, орон сууц, дэд бүтэцтэй холбоотой үйл ажиллагаануудын хэрэгжилтийг хангах үүрэгтэй. ЦАС-гийн зүгээс санхүүждэг хот байгуулалт, дэд бүтэцтэй холбоотой үйл ажиллагаануудад мониторинг хийх. Ажилтан нь мониторингод шаардлагатай техникийн хангалттай чадавхиар хангах зорилгоор холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах
- Орон сууц ба дэд бүтэцтэй холбоотой бохирдуулагчдын ялгарлыг бууруулах талаар ЦАС-гийн концепцийн баримт боловсруулах. ЦАС-гийн зүгээс санхүүжүүлж буй орон сууц ба дэд бүтцийн төслүүдээс үүдсэн нарийн ширхэгт тоосонцор 2.5, нарийн ширхэгт тоосонцор 10, NO_X, SO_X, озон ба CO₂ зэрэг бохирдуулагчдын буурсан байдлыг хэмжих механизмийг тодорхойлох,
- ЦАС-гийн тендэр ба гэрээний бэлтгэл, гүйцэтгэл зэрэгт дэмжлэг үзүүлэх
- ЦАС-гийн тайлагнах ажилд хувь нэмэр оруулах
- Гэрээлэгч, төслийн үр ашгийг хүртэгч, бусад төрийн байгууллага, хувийн хэвшил, эрдэмтэд, бусад оролцогч талуудтай хамтын ажиллагааны салбарыг тодорхойлохын тулд харилцан уялдаатай ажиллах.
- Хот байгуулалт, дэд бүтэцтэй холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээрх бодлого, шинжлэх ухааны нийтлэл, мэдээ зэргийн боловсруулалтад мониторинг хийх
- ЦАС-гийн зүгээс санхүүждэг хот байгуулалт, дэд бүтэцтэй холбоотой төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бусад бүх үүрэг.

Тавигдах шаардлага

Евроконсалт Мотт МакДоналд

○ Инженерийн болон бусад холбогдох чиглэлээр мастерийн зэрэгтэй
○ Холбогдох чиглэлээр хамгийн багадаа 3 жилийн ажлын туршлагатай
○ Монгол улсын агаарын бохирдлын бодлогын талаар өргөн мэдлэгтэй
○ Компьютерийн өргөн хэрэглээний програмууд дээр ажилладаг
○ Монгол хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай ба Англи болон бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
○ Харилцаа, холбооны өндөр ур чадвартай

ЦЭВЭР АГААР САНГИЙН (ЦАС) АЖЛЫН ДААЛГАВАР

Албан тушаал: Боловсруулсан түлшний асуудал хариуцсан ажилтан

Хугацаа: Байнгын ба үндсэн ажилтан

Ажиллах байршил: ЦАС-гийн байр, Улаанбаатар хот

Цалин хөлс: Цалин хөлсийн хэмжээг Төрийн албан хаагчийн тухай хууль ба Тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн, тухайн ажилтны боловсролын байдал, ажлын туршлагад тулгуурлан тогтооно.

Үндэслэл: Сүүлийн 10 жилд агаарын бохирдол нь хот суурин газар оршин суудаг Монголчуудын хувьд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудлуудын нэг болсон юм. SO₂ ба NO₂-ын хэмжээ маш ихээр нэмэгдсэн ба ялангуяа нарийн ширхэглэг тоосонцрын хэмжээ нь олон улсын стандарт хэмжээг сэтгэл түгшээх хэмжээнд хэтэрсэн болно. Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах тал дээр хэд хэдэн ажиллагаа хийгдсэн болно. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоог бүрдүүлсэн агаарын тухай 3 хууль батлагдсан. Үр дүнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ба Цэвэр агаар сан (ЦАС) зэрэг хоёр чухал ач холбогдолтой төрийн байгууллага байгуулагдсан юм. 2011 онд байгуулагдсан ЦАС нь Монгол улсад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлэх гол механизм юм.

Гол үүрэг даалгавар

ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын удирдлаган дор Боловсруулсан түлш хариуцсан ажилтан нь дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ:

- ЦАС-гийн зүгээс санжүүжиж буй боловсруулсан түлштэй холбоотой үйл ажиллагаануудыг хариуцах
- ЦАС-гийн зүгээс санжүүжиж буй боловсруулсан түлштэй холбоотой үйл ажиллагаануудыг хянах. Ажилтан нь мониторингод шаардлагатай техникийн хангалттай чадавхийг хангах зорилгоор холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана
- Нарийн ширхэгт тоосонцор 2.5, нарийн ширхэгт тоосонцор 10, NO_x, SO_x, озон ба CO₂ зэрэг ЦАС-гийн боловсруулсан түлштэй холбоотой төслүүдээс үүдсэн бохирдуулагчдын буурсан байдлыг хэмжих механизмийг тодорхойлох,
- Хагас коксжсон нүүрс, үртсэн түлш, хий ба сэргээгдэх түлш зэрэг төрөл бүрийн боловсруулсан түлшийн түгээлтийн сүлжээг судлах. Сэргээгдэх эрчим хүчийг бий болгохыг дэмжих зорилгоор ЦАС-д зориулан стратеги боловсруулах
- ЦАС-гийн тендэр ба гэрээний бэлтгэл, гүйцэтгэл зэрэгт дэмжлэг үзүүлэх
- Яамд, УБ хотын захиргаа, хагас коксжсон нүүрс үйлдвэрлэгчид, нүүрсний уурхай, ТББ ба хэрэглэгчид зэрэг нүүрсний үйлдвэрлэл ба боловсруулсан түлшний хөгжил дэх гол оролцогч талуудтай харилцан уялдаатай ажиллах.
- ЦАС-гийн тайлагнах ажилд хувь нэмэр оруулах, боловсруулсан түлштэй холбоотой бодлого боловсруулалтыг хянах, хувь нэмэр оруулах.
- ЦАС-гийн зүгээс санхүүждэг боловсруулсан түлштэй холбоотой төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бусад бүх үүрэг.

Тавигдах шаардлага

○ Инженерийн болон бусад холбогдох чиглэлээр мастерийн зэрэгтэй
○ Холбогдох чиглэлээр хамгийн багадаа 3 жилийн ажлын туршлагатай
○ Монгол улсын агаарын бохирдлын бодлогын талаар өргөн мэдлэгтэй
○ Компьютерийн өргөн хэрэглээний програмууд дээр ажилладаг
○ Монгол хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай ба Англи болон бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
○ Харилцаа, холбооны өндөр ур чадвартай

ЦЭВЭР АГААР САНГИЙН (ЦАС) АЖЛЫН ДААЛГАВАР

Албан тушаал: Нийгэм, эдийн засгийн асуудал хариуцсан ажилтан

Хугацаа: Байнгын

Ажиллах байршил: ЦАС-гийн байр, Улаанбаатар хот

Цалин хөлс: Цалин хөлсийн хэмжээг Төрийн албан хаагчийн тухай хууль ба Тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн, тухайн ажилтны боловсролын байдал, ажлын туршлагад тулгуурлан тогтооно.

Үндэслэл: Сүүлийн 10 жилд агаарын бохирдол нь хот суурин газар оршин суудаг Монголчуудын хувьд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудлуудын нэг болсон юм. SO₂ ба NO₂-ын хэмжээ маш ихээр нэмэгдсэн ба ялангуяа нарийн ширхэглэг тоосонцрын хэмжээ нь олон улсын стандарт хэмжээг сэтгэл түгшээх хэмжээнд хэтэрсэн болно. Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах тал дээр хэд хэдэн ажиллагаа хийгдсэн болно. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоог бүрдүүлсэн агаарын тухай 3 хууль батлагдсан. Үр дүнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ба Цэвэр агаар сан (ЦАС) зэрэг хоёр чухал ач холбогдолтой төрийн байгууллага байгуулагдсан юм. 2011 онд байгуулагдсан ЦАС нь Монгол улсад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлэх гол механизм юм.

Гол үүрэг даалгавар

ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын удирдлаган дор Нийгэм, эдийг засгийн асуудал хариуцсан ажилтан дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ:

- ЦАС-тай холбоотой төслүүдийн эдийн засаг ба нийгмийн бүрх талын асуудлыг хариуцаж ажиллах. ЦАС-гийн нийгэм эдийн засгийн нөлөөллийг хэмжих, хянах төлөвлөгөө боловсруулах. ЦАС-гийн Мониторинг, үнэлгээний стратегийн ахиц дэвшил, нөлөөллийг хэмжих талаар нэг бүлэг боловсруулах. Монгол улсын хувийн салбарт ажлын байр бий болгох, нэмэлт ашиг олох, чадавхи бий болгох, хөгжүүлэх зэрэг нөлөөллийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах
- Эн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоох ЦАС-гийн төлөвлөгдсөн үйл ажиллагааны зардлын ерөнхий зураглалыг боловсруулах. Төлөвлөгдсөн үйл ажиллагаануудын эдийн засаг ба нийгмийн талын зардлыг тодорхойлж, өөр бусал хувилбарыг санал болгох. Боловсруулсан түлшний хувилбаруудад зориулан худалдан авах чадамжийн механизм боловсруулах
- Төлөвлөгдсөн татаасын механизмын зардлын асуудлыг судалж, нарийн тооцоололд тулгуурлан хамгийн зохистой татаасын хэмжээг тогтоох. Хагас кокжсон нүүрс, хий, үртсэн түлш зэрэг боловсруулсан түлшний хувилбаруудыг дэмжих, үр ашгийн тооцоо/дүн шинжилгээ хийх,
- ЦАС-гийн тендэр ба гэрээний бэлтгэл, гүйцэтгэл зэрэгт дэмжлэг үзүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааны төсвийг судлах. ЦАС-гийн Гүйцэтгэх захирал ба ахлах нягтлан бодогчид төсөвлөлтийг процесст туслалцаа үзүүлэх. Боломжит гэрээлэгчдийн боловсруулсан санхүүгийн санал, төсвийг судлах.
- ЦАС-гийн тайлагнах ажилд хувь нэмэр оруулах
- ЦАС-гийн зүгээс санхүүждэг төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бусад бүх үүрэг

Тавигдах шаардлага

○ Эдийн засаг, нийгмийн ухаан болон бусад холбогдох чиглэлээр мастерийн зэрэгтэй
○ Холбогдох чиглэлээр хамгийн багадаа 3 жилийн ажлын туршлагатай
○ Монгол улсын агаарын бохирдлын бодлогын талаар өргөн мэдлэгтэй
○ Компьютерийн өргөн хэрэглээний програмууд дээр ажилладаг
○ Монгол хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай ба Англи болон бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
○ Харилцаа, холбооны өндөр ур чадвартай

ЦЭВЭР АГААР САНГИЙН (ЦАС) АЖЛЫН ДААЛГАВАР

Албан тушаал: Харилцаа, холбооны ажилтан

Хугацаа: Байнгын

Ажиллах байршил: ЦАС-гийн байр, Улаанбаатар хот

Цалин хөлс: Цалин хөлсийн хэмжээг Төрийн албан хаагчийн тухай хууль ба Тусгай сангийн тухай хуульд нийцүүлэн, тухайн ажилтны боловсролын байдал, ажлын туршлагад тулгуурлан тогтооно.

Үндэслэл: Сүүлийн 10 жилд агаарын бохирдол нь хот суурин газар оршин суудаг Монголчуудын хувьд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хувьд байгаль орчны хамгийн чухал асуудлуудын нэг болсон юм. SO₂ ба NO₂-ын хэмжээ маш ихээр нэмэгдсэн ба ялангуяа нарийн ширхэглэг тоосонцрын хэмжээ нь олон улсын стандарт хэмжээг сэтгэл түгшээх хэмжээнд хэтэрсэн болно. Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах тал дээр хэд хэдэн ажиллагаа хийгдсэн болно. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоог бүрдүүлсэн агаарын тухай 3 хууль батлагдсан. Үр дүнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо ба Цэвэр агаар сан (ЦАС) зэрэг хоёр чухал ач холбогдолтой төрийн байгууллага байгуулагдсан юм. 2011 онд байгуулагдсан ЦАС нь Монгол улсад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг санхүүжүүлэх гол механизм юм.

Гол үүрэг даалгавар

ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын удирдлаган дор Харилцаа, холбоо хариуцсан ажилтан дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ:

- ЦАС-нд зориулан харилцаа холбооны стратеги боловсруулах, түүний хэрэгжилтийг хянах. ЦАС-гийн бусад боловсон хүчнийг стратегийн тал дээр сургах, дадлагажуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллахад туслалцаа үзүүлэх
- Боловсруулсан түлш ба агаарын бохирдлын асуудлаар хэвлэлийн мэдэгдэл, мэдээ нийтлэл, цахим нийтлэл, баримт мэдээ, мэдээллийн багц, брошур зэргийг бэлтгэх. ЦАС-гийн үйл ажиллагаа ба тэдгээрийн үр дүнг тодотгох зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцан уялдаатай ажиллах
- Иргэд, төрийн байгууллагууд, түлш үйлдвэрлэгчид, түлш түгээгчид, ТББ, ОУСБ, донор байгууллагууд гэх зэргийг хамарсан олон нийтийн зөвлөлдөөнийг зохион байгуулах.
- Үндэсний телевиз ба Монголын Мянганы Сорилтын Сангийн Цэвэр агаар төслийн олон нийтэд таниулах үйл ажиллагаа ба олон нийтийн зөвлөлдөөний шилдэг туршлагыг судлах
- Процедурын гарын авлагыг багтаасан олон нийтийн зөвлөлдөөний механизмыг төсөл хэлбэрээр боловсуулахад туслалцаа үзүүлэх.
- ЦАС-гийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой боловсруулж буй бүх бүтээгдэхүүнүүдийн сайн чанарыг хангах ба хэвлэлд цацагдахаас өмнө бүх бүтээгдэхүүнүүдийг судлах.
- Олон нийтийн арга хэмжээ ба ЦАС-гийн зохион байгуулж буй бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. ЦАС-гийн үйл ажиллагаанд шаардагдах бусад үүрэг.

Тавигдах шаардлага

○ Сэтгүүл зүй, харилцаа холбоо болон бусад холбогдох чиглэлээр мастерийн зэрэгтэй
